

А.БЕРГСОНЫ БОЛОВСРУУЛСАН “ҮРГЭЛЖЛЭЛ” ГЭДЭГ ФИЛОСОФИ БАРИМТЛАЛ

Ц. Гомбосүрэн

МУИС, Нийгмийн шинжлэх ухааны сургууль

Түлхүүр үгс: Үргэлжлэл. <<Үргэлжлэл>> гэдэг А.Бергсоны ойлголтын философи уг сурвалж. Орон зайн нэг төрөл шинж. Цаг хугацааны нэг төрөл биш шинж. Амьдрал. Ухамсар.

Францын философич Анри Бергсон /1895 - 1914/ Өрнөдийн философид “гуманист антропологи” чиглэлийг үндэслэгчдийн нэг, “интуитивизмын төлөөлөгч”, “спиритуализмын төлөөлөгч” гэх мэтээр алдаршсан юм. Үүний хамт тэрээр амьдралын тухай философийн нэг өвөрмөц хувилбарыг бүтээгч хэмээн Францад төдийгүй дэлхийн философид хүлээн зөвшөөрөгдсөн сэтгэгч мөн.

Үргэлжлэлийн тухай философи баримтлал бол А.Бергсоны нийт философи байгууламжийг зангиддаг баримтлал юм. Тэрээр үргэлжлэлийн тухай ойлголтыг өөрийн анхны том бүтээл болох “Ухамсарт шууд өгөгдөгчүүдийн тухай туршлага” гэдэг 1889 онд хамгаалсан докторын диссертацидаа боловсруулжээ. Тухайн тэр үед уг ойлголтыг дэлхийн философийн хүрээнийхэн гоц анхааралгүй өнгөрсөн аж. Энэ нь тэр үед цаг хугацааны тухай объективист үзэл ноёрхож байсантай холбоотой бололтой.

“Ухамсарт шууд өгөгдөгчүүдийн тухай туршлага” бүтээл дэх “үргэлжлэл” /фр.: *duree*-, англ.: *duration*-.орос: *длительность*/ гэдэг категори бол цаг хугацааг субъективизм, психологизмын үүднээс ойлгосны үр дүн аж. Тэрээр энэ бүтээлээсээ гуч гаруй жилийн дараа бичсэн “Үргэлжлэл бол нэг зэрэг шинж. Эйнштейний харьцангуй онолоос шалтаглах нь” /1922/ зохиолдоо ч гэсэн уг категорийг бас л субъективизм, психологизмын үүднээс үндэслэн тайлбарласан байна. Харин 1907 онд хэвлүүлсэн “Бүтээгч хувьсал” гэдэг зохиолдоо үргэлжлэлийг онтологи утгаар авч үзсэн ажээ. Эдгээрийг

харгалзаад үргэлжлэлийн тухай А.Бергсоны философи баримтлал гэдэг хоёр зохиолд нь тулгуурлан авч үзэж буй болно.

**Нэг. Цаг хугацааны тухай А. Бергсоны субъектив,
психологи тайлбар, түүний философи уг сурвалж**

А.Бергсон хожим нь өөрөө дурсан бичсэнээр тэрээр шинжлэх ухааны онолд холбогдох судалгаанаасаа нэлээд хожуу метафизик ба психологид анхаарлаа хандуулсан байна. Тухайлбал докторын диссертаци нь механикийн суурь ойлголтуудыг авч үзэх зорилготой судалгаа байсан аж. Ийм судалгаанд цаг хугацааны асуудал чухал байр суурь эзэлсэн нь тодорхой. Харин түүний ийм үйл ажиллагааны явцад механикт, бүр тодруулбал физикт ярьж буй цаг хугацаа өөрийнх нь харгалзах философи ойлгоцтой үл тохирч, тэнд үргэлжлэлийн тухай өгүүлдэггүй нь түүнд анзаарагджээ. Бас математик ч гэсэн үргэлжлэлийн тухай асуудлыг мэдэрдэггүйг тэрээр мэдэж авсан байна. Тийм учраас цаг хугацааны тухай асуудлыг психологийн үүднээс шинжлэхэд анхаарлаа төвлөрүүлэх болжээ. Чухам үүний үр дүнд үргэлжлэлийн тухай түүний философи баримтлал боловсорсон түүхтэй.

Гэхдээ хэдийгээр А.Бергсон өөрийн философийг нэн өвөрмөц сургаал хэмээн үзэж, философичдын нэг хэсэг нь түүнийг философийн мухардмал бясалгалыг шинэ зам руу оруулж, философид хувьсгал хийсэн /см. об этом напр.: Ф. Гранжан. **Революция в философии. Учение А.Бергсона. М., 1913, с. 2/** хэмээн өргөмжилж, ер нь А.Бергсон үнэхээр ч бие даасан байдлаар үргэлжлэлийн тухай баримтлалаа боловсруулсан бололтой байдаг ч гэсэн уг баримтлалын угтал, арга зүйн баримжаа нь байж чадах үндэслэлүүдийг философийн түүхэнд олон сэтгэгч дэвшүүлж иржээ. Тухайлбал:

- Христос шашны онолч, философич Августин /354 - 430/ үзэхдээ: Бурхан тэнгэр цаг хугацаанаас гадна байдаг тийм утгаар мөнх. Бурхан тэнгэр ертөнцийг бүтээсэн тэр үед л цаг хугацаа бүтээгдсэн. Өнгөрсөн ба ирээдүй бол жинхэнэ оршихуйгүй. Гагцхүү одоо л байдаг. Одоо бол гагцхүү агшин мөн. Бид зөвхөн урсаж буй цаг хугацааг хэмждэг. Өнгөрсөн ирээдүй хоёрыг одоо гэж ойлгох ёстой. Учир нь, өнгөрсөн бол дурдатгал, ирээдүй бол хүлээлт бөгөөд гэтэл энэ хоёр /дурдатгал ба хүлээлт/ бол одоо мөн. Тийнхүү "өнгөрсөн юмсын

одоо", "одоох юмсын одоо", "ирээдүйн юмсын одоо" гэсэн гурван цаг хугацаа /3 одоо/ байдаг гэсэн ажээ. /см.об этом напр.: Бертран Рассел. История западной философии . Ростов- на – Дону. 1998, с. 404-405/.

- XVII зууны Францын философич Рене Декарт скептицизм бол баттай, туйлын үнэнд хүрэхэд чухал арга зүйн баримтлал мөн гэж үзсэний сацуу "би сэтгэж байна, иймд оршиж байна" гэдэг ганц үндэслэл л эргэлзээгүй байдаг. Учир нь, эл үндэслэл дэх эргэлзэх үйлдэл бол сэтгэхүйн ч үйлдэл, оршин байхуйн ч үйлдэл мөн гэж тайлбарласан ажээ. Декартын ашиглаж буй "сэтгэж байна" гэдэг илэрхийлэл нь "эргэлзэж байна", "мэдэрч байна", "ойлгож байна", "хүлээн авч байна", "үгүйсгэж байна", "хүсэж байна", "ургуулан бодож байна" гэх мэт олон үйлдлийг хамардаг тухай Б.Рассел бичсэн байдаг /см. об этом напр.: там же, с. 641/. Мэдрэхүйг Декарт сэтгэхүйд багтаасан шалтгаан гэвэл түүний бясалгалаар сэтгэхүй бол сэтгэлийн мөн чанар, сэтгэл нь гүн нойронд хүртэл бодож байдаг тул зүүдэнд орж буй мэдрэхүйг сэтгэхүйд хамааруулах ёстой ажээ.

- XVШ зууны Английн философич Дж.Берклигийн үзлээр хүн хувийн санаа буюу сэрлээ л мэдэрдэг. Юм оршин байна гэдэг бол заавал мэдрэгдэнэ гэсэн үг. Объект, сэрэл хоёр бол яг нэг зүйл мөн. Янз бүрийн санааны өөр өөр хуралдал бол чулуу, мод гэх мэт мэдрэгдэгч юмсыг бүрдүүлдэг.

Дж.Беркли ийм үзлийг онтологийн үүднээс илэрхийлсэн мэт В.И.Ленин болон түүнийг залгамжлагч диалектик материалист философичид шүүмжилж ирсэн билээ. Хэрэв Дж.Беркли уг үзлээ үнэхээр онтологийн үүднээс илэрхийлэсэн бол тийм шүүмжлэл зүйтэй байх байв. Гэтэл угтаа Дж.Беркли тийм субъектив идеалист үзлийг онтологийн үүднээс биш, харин гносеологийн үүднээс, бүр тодруулж хэлбэл сенсуализмын үүднээс сурталчилсан болохыг зарим судлаач илрүүлэн тайлбарладаг билээ (жишээ нь) энэ тухай: Ц.Гомбосүрэн, Берклийн идеализм: жинхэнэ байдал ба бидний хэвшмэл ойлгоц. – **Эрдэм шинжилгээний бичиг /Нийгмийн ухаан/. МУИС. № 2 /115/. УБ., 1996, 35-51 дэх талд үзнэ үү.** Улмаар Дж.Беркли тийм сенсуалист /гносеологи/ субъектив идеализмынхаа үүднээс орон зай, цаг хугацаа хоёрыг санаанаас /сэрлээс/ гадуур авч үзэхийг шүүмжилдэг байжээ.

-XIX зууны Германы сонгодог философийг үндэслэгч И.Кантын философи үзлийн үүднээс мөн чанар бол "бидэнд хүртээлгүй юм" мөн. Бид зөвхөн үзэгдлийг ажиглан бясалгаж, эмхлэн цэгцэлж, тэдгээрээ "орон зай", "цаг хугацаа", эсвэл байгалийн тодорхой хууль мэтээр тайлбарладаг. Орон зай бол гадаад мэдрэмжийн априори хэлбэр, харин цаг хугацаа бол дотоод мэдрэмжийн априори хэлбэр мөн.

А.Бергсоны философийн сургаалд нөлөө үзүүлсэн болон үзүүлсэн байж болох утгаар философийн түүхийн зарим төлөөлөгчийн холбогдох үзлийг ийнхүү нэн хураангуйгаар дурдлаа. Гэхдээ А.Бергсон бол бусдын үзлийг зүгээр л хуулбарласан гэсэн санааг энд үндэслэх гээгүй юм. Харин А.Бергсон цаг хугацааны тухай өвөрмөц баримтлалаа боловсруулахад шууд ба дам аль нэг байдлаар нөлөө үзүүлэх чадвартай, ер нь тэгж үзүүлсэн ч байх учиртай тийм онолыг философийн түүхэн дэх олон сэтгэгч бий болгосон гэдгийг гэрчлэхийг энд зорьсон юм. Ингэхдээ А.Бергсонд тэдний холбогдох онолууд арга зүйн тодорхой ач холбогдолтойгоор ямар нэг байдлаар нөлөөлсөн болохоос агуулгын хувьд шууд хуулбарлагдсан биш билээ. Жишээ нь А.Бергсоны зүгээс зарим философичийн боловсруулсан дотоод мэдрэмжийг онцолдог философи баримтлалыг нь уламжлахдаа цаг хугацааг дотоод мэдрэмжтэй, субъектив чанартай холбон үздэг И.Кантын үзлийг илүү их онцолсон аж. Гэхдээ цаг хугацаа бол И.Кантын хувьд өмнө дурьдсанчлан дотоод мэдрэмжийн априори хэлбэр мөн ахул А.Бергсоны "Ухамсарт шууд өгөгдөгчүүдийн тухай туршлага" бүтээлд зааснаар тэр /цаг хугацаа/ нь "Би-гийн" бясалгалын, дотоод мэдрэмжийнх нь агуулга өөрөө мөн. Ийнхүү цаг хугацааны тухай А.Бергсоны баримтлал нь философийн түүхэн дэх зарим сургаалтай арга зүйн хувьд сенсуалист, субъектив шинжтэйгээрээ тодорхой байдлаар адилсан холбогдсон болохоос агуулгаараа тэдгээрээс чухал ялгаа бүхий ажээ.

А.Бергсон ухамсрыг онцлон судалсан нь Р.Декарт тэгж онцолсныг арга зүйн хувьд дагасан мэт байдаг. Гэхдээ ухамсрын мөн чанарыг Р.Декарт сэтгэхүй гэж үзсэн бол А.Бергсон мэдрэхүй гэж үзсэн арга зүй бүхий юм. Ухамсрыг Р.Декарт нэлээн хийсвэрлэж, авч үзсэн бол А.Бергсон тодорхой байдлаар авч үзсэнийг бас дурьдъя.

Францын энэхүү сэтгэгч цаг хугацаа бол бодит байдлыг биетэйгээр илэрхийлэгч элемент, хөдөлж буй тодорхой цэгийн зохих хэмжигдэхүүн гэж үзэх болон цаг хугацаа бол хүн төрөлхтөний амьдралын тодорхой хэмжээ ба хэмжигдэхүүн гэж үзэх хоёр адил бишийг сэтгэл судлалын аргаар тогтоож, ийм үр дүнгээ философи сургаалынхаа үндэс болгосон байна. Үүнд, бид амьдралынхаа өөр өөр үед тухайлбал амьдралынхаа эхэнд ба төгсгөлд, яарч сандарсан, тэвчээрээ алдсан, эсвэл амар тайван буй зэрэг нөхцөлд цаг хугацааг янз бүрээр мэдэрч байдаг баримтыг тэрээр философи тогтолцооныхоо нэн чухал зарчим болгожээ. А.Бергсон ийм субъективист байрнаас цаг хугацааг ойлгоод, түүний /цаг хугацааны/ гол онцлог бол түүний үл хуваагдагч, бүхэллэг чанар, өөрөөр хэлбэл түүний тус тус агшинд хуваагдах боломжгүй байдал мөн гэж үзсэн байна. Тэрээр чухамхүү ийм онцлогийг нь чухалчилсны үндсэн дээр цаг хугацааг "үргэлжлэл" хэмээн томъёолсон аж. Энэ нь үргэлжлэл /өөрөөр хэлбэл субъектив, психологи цаг хугацаа/ бол өнгөрсөн, одоо хоёр болон ухамсрын янз бүрийн төлөв байнга харилцан нэвтрэлцдэг байхыг, шинэ шинэ хэлбэр ямагт бүтдэг байхыг, хөгжил ба бүрэлдлийг тус тус ямагт шаарддаг гэж үзэхэд хүргэдэг. Ийнхүү цаг хугацаа бол шинжлэх ухааны танин мэдэхүйд ярьдагчлан биес орших об'ектив хэлбэр биш, харин хүн төрөлхтөний ахуй, түүх, соёл зэргийн үндэслэгээ, өөрөөр хэлбэл хүн төрөлхтөний орших хэлбэр мөн гэж А.Бергсон үзжээ.

А.Бергсон "Ухамсарт шууд өгөгдөгчүүдийн тухай туршлага" гэдэг зохиолдоо <<үргэлжлэл /тодорхой цаг хугацаа/>> гэдэг ойлголтыг боловсруулсан нь ухамсрын тухай сонгодог философи дахь субстанцлаг үзлүүдийг шүүмжилж, улмаар түүний /ухамсрын/ тухай өвөрмөц ойлголт боловсруулсантай нь уялддаг. Үүнд, түүний тайлбараар ухамсрын нэгдмэл байдал бол цаг хугацаат шинжид нь, өнгөрсөн одоо хоёрын тасралтгүй "нэгдэгч" харилцан үйлдэлд байж, түүний /ухамсрын/ янз бүрийн давхраа ба төлвүүд байнга харилцан нэвтрэлцэх замаар нэгдмэл бүхэл болж нягтардаг байдлаар хангагддаг.

Тийнхүү А.Бергсоныхоор ухамсрын мөн чанар нь үргэлжлэл мөн. Тийм аваас ухамсрын өмнөх төлвүүд нь дараахь төлвүүдээ тодорхойлдог гэхийн

аргагүй байдаг. Учир нь, бид судалгаандаа л өмнөх ба дараахь төлөв гэж болзон ярих тохиолдол байдаг болохоос угтаа тэгж тогтоогдох төлвүүд байдаггүй. Тодруулан дурьдвал А.Бергсоны үзлээр ухамсар бол янз бүрийн төлвийн цогц биш, харин тэдгээрийн харилцан нэвтрэлцэл, иймд хуваагддаггүй үйл явц тул тэндээс ямар ч тогтворт зүйлийг онцлох боломжгүй байдаг. Энэ бол сэтгэлийн аливаа гүн үйлдэл ухамсарт ганц удаа л бий болоод дахин давтагддаггүй гэсэн үг юм.

А.Бергсоны үзлээр оюуны амьдралд давтагдалт тийнхүү байдаггүй тул тэнд хууль огт үйлчилдэггүй. Тиймээс бид үйлдлийнхээ үр дүнг ямар болохыг тогтоох, ирээдүйгээ урьдчилан харах зэрэг аваас бололцоогүй байж, бидний ухамсар тийнхүү цаг хугацааны нягтралд, бүхэл байдалд нь буюу үргэлжлэлд илэрч байдаг. Тийм илрэл нь санаа, ой дурсамж, сэдэл, перцепци, хайр, догдлол, үзэн ядалт, хүсэл гэх мэт янз бүрийн төлөв байдалд байдаг хэмээн А.Бергсон үзсэн юм.

Ухамсрыг тасралттай биш, харин бүхэллэг шинжтэй хэмээн үндэслэх замаар оюуны амьдралд хууль үйлчилдэггүй хэмээх дүгнэлтэнд А.Бергсон хүрсэн нь нэн түрүүнд түүний дараахь хоёр ойлголттой уялдаж байдаг. Үүнд, түүний тайлбараар амьдрал бол бөхөж буй янз бүрийн "тундаснаас" байнга "бий болдог" эмх цэгцгүй материд нөлөөлөх үйлдлийн чиг хандлага ба бололцоо мөн.

Хоёр дахь нь хуулийн тухай ойлголт мөн. Тэрээр хууль бол бие биеэ нөхцөлдүүлэгч хоёр үзэгдлийн харилцаа нэг төрлийн орон зайд нөхөн үйлдвэрлэгдэх чадвар мөн гэж үздэг аж. /см.об этом: Анри Бергсон. Творческая эволюция. М., 1998, с.227-231 и др / Өөрөөр хэлбэл хуулийн тухай яриа бол гагцхүү ухамсраас гадны үзэгдлүүдэд бололцоотой аж.

Хуулийн тухай А.Бергсоны ойлголт нь тийнхүү орон зай нэг төрлийн байж болдог тухай үзэлд үндэслэдэг. Түүнийхээр орон зай бол гадаад тал, нэг зэрэг шинж, байрлал, дэг журам, тоон ялгарал, төвшний ялгаа гэх мэтийн олон янз төлөв мөн. Үргэлжлэл ч бас олон янз байдаг. Үүнд, үргэлжлэл бол дараалал, хэв маяг, нэг төрөл биш шинж, чанарын ялгаа зэргийн олон янз төлөв юм. Тийнхүү орон зайн олон янз, үргэлжлэлийн олон янз хоёр бол

гадаад дотоод өөр өөр хэв маяг мөн хэмээн Ж.Делёз 1966 онд хэвлүүлсэн "Бергсонизм" гэдэг бүтээлдээ тэмдэглэсэн байдаг. Ийм хоёр янзын байдлыг бас: 1) Тоон ба тооны өөр өөр хувилбарын, өөрөөр хэлбэл тасралттай аж: 2) Чанарын ба үл тасралтат /үргэлжлэлийн/ хэмээн ойлгож болох тухай ч Ж. Делёз дурьдсан байдаг /см. об этом: А.А.Трицанов. Бергсонизм. – Постмодернизм. Мн., 2001, с. 76 /

А.Бергсон үргэлжлэлийг үл тасралтат шинж бүхий хэмээн үздэг нь түүнийг бас нэг төрөл биш шинж бүхий хэмээн тайлбарлахад хүргэсэн ажээ. Энэхүү <<нэг төрөл биш шинж>> гэдэг ойлголт А.Бергсоны хувьд <<цаг хугацаа шууд, ганц өгөгддөг>> гэсэн утга бүхий юм. Тийм аваас үүний эсрэг <<нэг төрөл шинж>> гэдэг ойлголтыг цаг хугацаанд холбогдуулах юм бол түүнийг /цаг хугацааг/ тэнцүү хэсгүүдэд хувааж, тэдгээр хэсгийг хэмжиж болохыг, тийнхүү цаг хугацааны хэсгүүд давтагдаж байдаг гэсэн санааг тэрээр илэрхийлэхээр байдаг. Гэвч А.Бергсон <<нэг төрөл шинж>> гэдэг ойлголтыг цаг хугацааны тухай өөрийнхөө философи ойлголтод холбогдохгүй гэж <<"Ухамсарт шууд өгөгдөгчүүдийн тухай туршлага">> зохиолдоо тайлбарлажээ. Үүнд /см. об этом напр.: Анри Бергсон. Собрание сочинений . Том первый, с. 96-100/: одон орны шинжлэх ухаан цагийг адил тэнцүү хуваагаад тэдгээр хэсгээ хэмжиж байдаг нь үргэлжлэлийг хэмжиж буй нь биш юм. Тухайлбал цагийн зүүг ширтэн тоолж буй тохиолдол бол үргэлжлэлийг /тодорхой цагийг / хэмжиж буй байдал биш. Цагийн зүүний заалт бол надаас гадны орон зайд буй нэг зэрэг агшинг илэрхийлдэг. Харин "үргэлжлэл" гэдэг А.Бергсоны ойлголт бол ухамсрын баримтуудын харилцан нэвтрэлцлийг, тэдгээрийн зохион байгуулалтыг илэрхийлэгч субъектив ойлголт мөнийг өмнө өгүүлсэн билээ. Иймд энэ жишээ бол үргэлжлэлд биш, харин орон зайд, нэг зэрэг шинжид холбогдоно гэж А.Бергсон тайлбарласан байдаг.

Тийнхүү А.Бергсоны үзлээр гагцхүү орон зай нэг төрлийн байж, орон зайд оршигч юмс хуваагдагч олонлогийг бүрдүүлж, аливаа тийм олонлогийг орон зайд л бүрдүүлэн олж авч болдог. Гэтэл орон зайд үргэлжлэл байдаггүй /см.об этом напр.: там же, с. 102-103/. Биднээс гадна бол үргэлжлэлээс гагцхүү одоо буюу нэг зэрэг шинж л байдаг. Гадаад юмс өөрчлөгдөж байдаг ч

гэсэн тэдгээрийн олон янз агшин аваас өөрийг нь дурсан санагч ухамсар дотор л нэг нь нөгөөгийнхөө дараа гарч ирж байдаг. Харин угтаа бол орон зай дотор үргэлжлэлийг байрлуулж болдоггүй бөгөөд нөгөөтэйгүүр гадаад юмс үргэлжилж болдоггүй.

Товчоор хэлбэл А.Бергсоны үзлээр орон зай, түүн дотор оршигч юмс биднээс гадна, нэг төрлийн шинжтэй буюу давтагдагч, олон, харин үргэлжлэл бол бидэн дотор, ганц, тодорхой байдаг. **/см.об этом напр.: там же, с.148-149/**. Тэрээр чухамхүү ийм үзлийнхээ үүднээс И.Кантын сул тал нь нэг талд бидэнд хүртээлгүй юмсыг, нөгөө талд хоёулаа нэг төрлийн орон зай, цаг хугацааг байрлуулсанд байдаг хэмээн шүүмжилжээ **/см.об этом напр.: там же, с.152/**. Мөн цаг хугацааг механикийн шинжлэх ухаан болон түүнд үндэслэдэг натурфилософи аваас орон зайлаг шинжтэйгээр, үүнд цагийн зүү байрлалаа шилжүүлдэг шиг нэг агшнаас нөгөө агшин гарч ирдэг цуваа хэмээн үздэг бол А.Бергсон түүнийг /цаг хугацааг/ хүний амьдрал, туршлаганд үл давтагдагч, бүхэллэг, нэг удаагийн шинжтэй байдаг хэмээн философидсон байна.

Хоёр. Үргэлжлэлийг ухамсрын өвөрмөц онтологи

үзэгдэл хэмээн авч үзсэн нь

А.Бергсон анхан үеийн олон чухал бүтээлдээ үргэлжлэлийн тухай асуудлыг дэвшүүлэн боловсруулснаа гүнзгийрүүлэх замаар түүний талаар нэлээд цэгцэрсэн онтологи сургаал бүтээх ажлыг "Бүтээгч хувьсал" зохиолдоо хэрэгжүүлсэн билээ.

"Бүтээгч хувьсал" зохиол бол А.Бергсоныг өвөрмөц нухацтай сэтгэгч, авъяаслаг зохиогч мөний нь хувьд улам алдаршуулж, улмаар 1927 онд тэрээр утга зохиолын салбар дахь Нобелийн шагнал хүртсэнийх нь гол үндэс болсон бүтээл ажээ. Тэрээр энэ номондоо өмнөх бүтээлүүдийнхээ хүрээнд боловсруулсан философи баримтлалуудаа шинэ шинэ материалд үндэслэн дахин хянаж, улмаар олон чухал асуудал санаа нэмэн дэвшүүлсэн болно. Чухам үүнийхээ ачаар үргэлжлэлийн тухай философи баримтлалаа шинэ агуулга, шинэ утга бүхий болгосон аж.

Гэхдээ энд нэг зүйлийг зориуд тэмдэглэх хэрэгтэй санагдаж байна. Үүнд, "Бүтээгч хувьсал" зохиол бол А.Бергсоны өмнөх зохиолуудынх нь адилаар философи сэтгэлгээний түүхэн дэх чухал чухал үр дүнг өөртөө шингээсэн байдаг. Өөрөөр хэлбэл А.Бергсоныг өвөрмөц сэтгэгч гэж үнэлдэг нь түүнийг философи сэтгэлгээний түүхээс салгасан санаатай биш, харин тэрхүү түүхийн чухал чухал ололтонд бүтээлчээр хандан, судалгааныхаа шинэ материалуудад үндэслэн тэдгээр ололтыг шинэ агуулга, шинэ утгатай болгон гүнзгийрүүлсэн хэмээн францын эл философичид үнэлгээ өгч буй хэрэг мөн. Жишээ нь: прагматизм, Герман дахь амьдралын тухай философи, эмпириокритицизм, имманент философи, неореализм зэрэг дэх онолын зарим баримтлалын хүчтэй нөлөө "Бүтээгч хувьсал" зохиолд байгаа нь түүний боловсруулсан <<ухамсар>>, <<үргэлжлэл>>, <<бүтээгч хувьсал>> зэрэг ойлголтонд шууд холбогддог.

А.Бергсон өмнөх бүтээлүүддээ цаг хугацааг механикчилж биш, натурфилософид ойлгодог биш, харин тодорхой, бүхэллэг, үл тасалдалт зэрэг шинжтэйг нь психологи, танин мэдэхүйн сургаал зэргийн үүднээс онцлон авч үзсэн тайлбар голлон хийсэн бол "Бүтээгч хувьсал" зохиолдоо өмнөх дүгнэлтүүдээ гүнзгийрүүлэх замаар шууд туршлага дахь тодорхой цаг хугацаа болох үргэлжлэлийг ямар шүү онтологи бодит байдал мөнийг илрүүлэхэд анхаарлаа ихээхэн хандуулсан байна. Тэгээд: цаг хугацаа бол психологи амьдралын эд эс нь мөн /см.об этом напр.: Анри Бергсон. Творческая эволюция, с.42/ гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Энд дурьдаж буй <<цаг хугацаа>> гэдэг ойлголт аваас механик, натурфилософи утгатай биш, харин А.Бергсоны <<үргэлжлэл>> гэдэг ойлголтын утгатай буй. Үүний нэг нотолгоог дурьдахад А.Бергсон: <<манай амьдралын эд эс нь яг мөн гэж бид мэдэрдэг тодорхой цаг хугацаанд ...матери, санаа хоёр оршдоггүй>> /там же, с.239/ гэж бичсэн байдаг.

Харин А.Бергсоны энэ онтологи дүгнэлтийг үгийнх нь махчилсан утгаар ухаарвал, тухайлбал зөвхөн ерийн ярианы утгын <<амьдрал>> гэдэг ойлголтонд хамааруулбал явцуурал болно. Үүнд, түүний хувьд амьдрал бол хөгжингүй амьд организм дахь үр хөврөлөөс үр хөврөл рүү хүрдэг урсгал,

тийнхүү агшин бүрт ямар нэг юм бүтээгч мөн /см.об этом: там же, с. 61-62/
Энэ дурьдсантай уялдуулан тэмдэглэхэд А.Бергсоны хувьд үргэлжлэл бол цаг
хугацааны үл тасалдал биш, харин огт шинийг тасралтгүй боловсруулахуй,
шинэ шинэ хэлбэрийг бүтээхүй мөн бөгөөд чухам ийм утгаар бидний ухамсард
орчлон үргэлжилдэг /см. об этом напр.: там же, с.47/. Чухам ийм утгын
үүднээс тэрээр: бид үргэлжлэлийг <<дахин дотор нь орж болдоггүй урсгал
хэмээн хүлээж авдаг. Үргэлжлэл бол манай ахуйн үндэс, бид холбогддог
юмсын субстанции нь өөрөө мөн гэдгийг мэдэрч байдаг >> там же, /с.71/ хэмээн
өгүүлсэн юм.

"Бүтээгч хувьсал" зохиолд ахуй гэж юу болох тухай нарийвчилсан
тодорхойлолт томъёологдоогүй байна. Гэхдээ ахуй бишийн тухай А. Бергсоны
нухацтай эргэцүүлэл /см. об этом напр.: /там же,/ с.265-287, 309, 312 и др./
нь ахуй гэж тэрээр юуг ойлгосныг илэрхийлэх бололцоо олгож байна. Үүнд,
түүний философидолтын дагуу илэрхийлбэл ахуй бол тухайн шууд туршлагад
өгөгдөнө. Харин ахуйг биш бол огт байхгүй юм биш, гагцхүү тухайн тохиолдол
шууд туршлаганд үл өгөгдөгч оршихуй мөн гэж тэрээр үзсэн юм. Үүнд: <<танин
мэдэхүйн хувьд <<үл оршигч>> юмны тухай санаа аваас <<оршигч>> хэмээн
танин мэдэгдэж буй тэр л юмны тухай санаанаас агуулга ихтэй байдаг. Яагаад
гэвэл үл оршигч юмны тухай санаа бол <<оршигч>> юмны тухай санаа
гарцаагүй мөн байж, түүнээс гадна энэ юмыг нийт бэлэн бодит чанарт
хамааруулдаггүй ойлгоц мөн>> /там же, с.277 / гэж "Бүтээгч хувьсал" зохиолд
онцлон тэмдэглэсэн юм.

Дүгнэн хэлбэл ахуй бас ахуй бишийн тухай А.Бергсоны эл онтологи
ойлголт нь материализм, объектив идеализм, шашны философи зэрэгт
онцолдог объектив оршихуйг биш, харин хүний ухамсар, шууд туршлагын
бүтээгдэхүүн болдог тийм субъектив оршихуйг онцолдог.

А.Бергсон <<үргэлжлэл>> гэдэг ойлголтоо тодорхойлоход нь гарцаагүй
хөндөгдөж буй << амьдрал >> гэдэг ойлголт түүний хувьд ямар агуулга бүхийг
одоо авч үзье. Тэрээр амьдрал, амьд биесийн тухай шинжлэх ухааны
ололтуудыг дэлгэрэнгүй шинжилснийг энд үл хөндөөд харин түүнээсээ

философи ямар дүгнэлтүүд хийж, ямар чухал философи томъёоллууд боловсруулсныг нь онцлох юм.

“Бүтээгч хувьсал” зохиолд амьдралыг олон талаас нь өөр өөр үндэслэгээний үүднээс тодорхойлсон байна. Тухайлбал:

- Амьдрал бол хувьсал /эволюци/ мөн.

- Амьдрал бол матери луу шидэгдсэн ухамсар мөн гэдэг үзэл. А.Бергсоны эл тодорхойлолт бол түүний эволюционизмтай уялддаг. Үүнд, түүний бичсэнээр <<...Аристотелиос эхлэлтэйгээр байгалийн философийн ихээхэн хэсгийг гуйвуулж ирсэн суурь төөрөгдөл нь ургамлын, инстинктив, оюун ухааны гэдэг амьдралыг зөвхөн нэг л хандлагын хөгжил дэх дараалсан гурван төвшин хэмээдэгт оршдог. Гэтэл энэ нь нэг үйл ажиллагаа өсөлтийнхөө явцад салбарласан гурван өөр чиглэл мөн. Энэ гурвын ялгаа нь идэвхт шинжийн ч, төвшингийн ч ялгаа бишээ. Учир нь. энэ бол байгаль шинжийн ялгаа мөн>> /там же, с.151/. Тэрээр ийм үзлийнхээ үүднээс: ургамлын амьдрал, амьтны амьдрал хоёр бие биеэ нөхөж, бас бие биедээ эсрэг байдаг шиг интеллект, инстинкт хоёр бас бие биедээ эсрэгийн сацуу харилцан нэгнээ нөхдөг гэж үзсэн юм.

- Амьдрал бол төлөвлөгдөөгүй хэлбэрүүд нэг нь нөгөөгөө халан тасралтгүй бүтэхүй мөн гэдэг үзэл /см. об этом напр.: там же, с.63, 111/. А.Бергсоны хувьд хэлбэр бол хувьслын тодорхой үеийг тогтвортой дүр төрх болгон чухалчлахуй /см. об этом там же, с.290-291/ мөн. Гэтэл бие угаа хэлбэрээ тасралтгүй сольдог тул хэлбэр гэх юм хэрэг дээрээ байдаггүй /амьдралын тухай философид ярьдаг бие бол онтологи зүйл биш, харин ухамсар дахь түүний бүтээл өгөгдөхүүн байдгийг мартаж болохгүй/. Тэрээр хэлбэрийн тухай ийм үзлийнхээ үүднээс амьдралын үйл /функци/ бол тодорхой биш чанарыг матери луу нэвтрүүлэхүй мөн гэдэг томъёолол бий болгожээ /см. об этом там же, с.143/. Эл томъёолол дахь <<тодорхой биш чанар>> гэдэг ойлголт аваас амьдрал хувьслынхаа явцад урьдчилж төлөвлөөгүй хэлбэрүүд аяндаа бүтээж байдгийг илэрхийлдэг.

- Амьдрал бол сацрал хэлбэртэй хөгжил мөн чанар нь болж өгдөг тийм хандлага мөн гэдэг үзэл. Үүнд, сацран өргөжиж буй хувьслын үйл явц болбоос

анхандаа бие биеэ нөхөн гүйцээж, нийлэлдэж байдаг бүрэлдэхүүн хэсгүүдийг нэг зэрэг өсөхийнх нь хирээр тэдгээрийг зааглаж байдаг хэмээн А.Бергсон тайлбарласан юм /см. об этом напр.: там же, с. 121, 136 /.

Ийнхүү А.Бергсоны философид сурталчилдаг амьдрал бол амьд бие өөрчлөлтийн бүтээл болж, үргэлжилж, өөрөөр хэлбэл өнгөрсөн нь одоод ирж, одоод үйлдэл бүхий байдаг тийм байдал мөн. /см. об этом: там же, с.51/ Энэ ойлголт ганц хүн төрөлхтнийг биш, харин нийт амьд ертөнцийг хамаардаг. Харин <<үргэлжлэл>> гэдэг ойлголт аваас зөвхөн оюун ухааны амьдралд, өөрөөр хэлбэл хүн төрөлхтөний амьдралд холбогддог аж.

Орчлонгийн юмс, түүний дотор ургамлын ба амьтны амьдрал хэрвээ бидэнтэй, хүн төрөлхтөний шууд туршлагатай холбогдож байвал тэдгээр нь үргэлжилдэг /см. об этом напр.: там же, с. 47-48/ гэж А.Бергсон үзсэн юм.

Резюме

В данной статье <<Философская концепция А.Бергсона о длительности>> автор преследует рассматривает эволюционные этапы развитие содержания концепции о времени, разработанной французским философом А.Бергсоном. На основе своего анализа автор к приходит выводу, что если в первых трудах А.Бергсона, особенно в работе <<Опыт о непосредственных данных сознания>> /1889/ время объясняется с психологической и субъективистской позиций, то в последних его трудах, особенно а именно, в работе <<Творческая эволюция>> оно /время/ рассматривается как понятие определенного онтологического явления, которое понимаемое в определенном онтологическом духе и тем самым понятие А.Бергсона о времени как длительности в корне отличается от других понятий о времени, разработанных представителями различного рода натурфилософских учений.